

## **ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН, ЧИНГЭЛЭГТ ДУГААР ОЛГОХЫГ ХҮССЭН АЛБАН БИЧИГТ ДАРААХ МАТЕРИАЛЫГ ХАВСАРГАЖ ИРҮҮЛНЭ.**

1. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг эзэмшигч хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар (нотариатаар баталгаажуулсан байна.);
2. Импортоор шинээр оруулж ирсэн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг бол техникийн паспорт болон үйлдвэрлэгчийн дагалдах бичиг;
3. Ашиглагдаж байгаад импортоор оруулж ирсэн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн гэрчилгээ, тухайн улсын эрх бүхий байгууллагаас техникийн шаардлага хангаж байгааг тодорхойлсон дүгнэлт, тухайн улсын бүртгэлээс хассан тухай тодорхойлолт, тэмдэглэл;
4. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг нь төмөр замын тээврийн хөдөлгөөнд тэнцэх эсэх тухай төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон ажлын хэсгийн дүгнэлт, эрх бүхий байгууллагын баталгаа;
5. Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг үйлдвэрлэх, угсрах, засварлах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын баталгаажуулсан баримт бичиг;
6. Импортоор шинээр оруулж ирсэн тохиолдолд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн гаалийн бүрдүүлэлт хийснийг нотлох мэдүүлэг, баримт.